

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр: “Улаанбаатар бүк” ХК

Хаяг, утас: Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байр.
Утас: Утас: 70001182, 88079542, .

Хурал хуралдах огноо, цаг, газар: “Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 4-р сарын 22-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байранд хуралдуулна.

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: “Улаанбаатар БҮК” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 3-р сарын 4-ний өдрийн № 2015/07 тоот тогтоол

Олон нийтэд зарлах огноо: 2015-03-06

Бүртгэх өдөр: 2015-03-16

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:

2015-03-11

Хүргүүлсэн огноо Хурлын баримт, бичгийн хуудсын тоо 30 ш ширхэг,
..... хуудас

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА** /Л.Нарандаваа /2015 оны 3 дугаар сарын 6 –ний өдөр

ХҮЛЭЭН АВСАН :
БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН /..... /..... оны
дүгээр сарын –ний өдөр

Дээрх мэлээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж, Санхүүгийн зохицуулах хороо, ҮЦТТГХТ \компани нээлттэй болсны дараа Монголын хөрөнгийн бирж\ -д хүргүүлнэ.

**“УЛААНБААТАР БҮК” ХК -ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4-р сарын 22-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах өөрийн компанийн байранд болно. Хурлаар доорхи асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. 2014 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. 2015 оны Төлөөлөн Удирдах зөвлөлийн төсөв батлах тухай;
4. Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах
Бүртгэлийн өдөр: 2015.0.3.16**

1

Холбогдох баримт бичигтэй Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах “Улаанбаатар БҮК” ХК-ийн байранд ажлын өдрүүдэд, 9.00-18.00 цагуудад танилцаж болно.

Хурал зохион байгуулах комисс:
Утас: 70001182, 88079542, .
E-mail: law@ubbuk.mn, ubbuk2@yahoo.com

**ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДСОН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ,
БЭЛЭН БОЛГОХ ХУГАЦАА**

№	Баримт бичиг	Бэлэн болгох эцсийн хугацаа
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол	2015-3-4
2	Хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар	2015-03-05
3	“Улаанбаатар БҮК”ХК-ийн товч танилцуулга	2015-03-05
4	2014 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга	2015-3-06
5	Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийн танилцуулга	2015-3-05
6	Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигчдийн нэрс, танилцуулга	2015-3-05
7	Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн нэрс, танилцуулга	2015-3-05
8	Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төсөл	2015-3-05
9	ХЭХ-ын тогтоолын төсөл	2015-3-05
10	Хурлын санал хураах хуудас	2015-3-05



**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015.03.04

№2015/07

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ
ТУХАЙ**

“Компанийн тухай” хуулийн 60-р заалт, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журам”-ын 2.2 дахь заалт болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 03-р сарын 04-ний өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. “Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 4-р сарын 22-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байранд хуралдуулсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1. 2014 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

2.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;

2.3. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2015 оны төсөв батлах тухай;

2.4. Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;

2.5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

3. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2015 оны 3- сарын 6-ны өдөр байхаар тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 3-р сарын 16-ны өдрөөр тогтоосугай.

5. Хурал зохион байгуулах комисс буюу Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Тооллогын комиссын даргаар Хуульч Л.Нарандаваа

Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-Д.Байгалмаа
Хүний нөөцийн менежер, ЗААХ-ийн дарга Х.Гулбарша
Санхүү хэлтсийн бэлэн мөнгөний нярав Т.Даваа

6. Хурал зохион байгуулах комисс /Н.Нарандаваа-д/:

6.1. Хурлын зарыг өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах,

хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх зэргээр зохион байгуулж хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг даалгасугай.

6.2. Дараах бичиг баримтуудыг Компанийн төв байр, хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер диллерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:

-Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол,
-2014 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга

-Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийн танилцуулга

-Компанийн ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн нэрс, танилцуулга

-Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төсөл

-Хурлын санал хураах хуудас

-Компанийн хуулийн 65.6-д заасан бусад баримт бичиг

7. Санал хураах хуудасны загварыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2015 оны 4-р сарын 22-ний өдрийн 11.00 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдан зохион байгуулж, удирдахыг ТУЗ-ийн дарга Н.Хунцэнгэлд даалгасугай.

10. Хурлын бэлтгэл ажлыг зохих журмын дагуу бүрэн хангаж, хурлыг заасан хугацаанд хууль, журамд нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисст/дарга н.Нарандаваа-д/даалгасугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.НЯМХҮҮ